



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 1 сарын 27 өдөр

Дугаар А/11

Мандалговь


Харъяалалгүй ахмад настнуудад  
хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "л" Ахмад настны тухай хуулийн 12.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Харъяалуулсан Аж ахуйн нэгж, албан байгууллага нь дампуурсан, татан буугдсан болон харъяалалгүй байгаа 53 ахмад настны нэрсийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан дээрх харъяалалгүй 53 ахмад настанд хүндэтгэл үзүүлэхийг Тамгын газрын дарга (Б.Оюунчимэг), Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Сэржмядаг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ